



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/163

Номгон

Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний
105 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд
хөрөнгө зарцуулах тухай


Цэргийн албаны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.8, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор баталсан Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг ашиглах журмын 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд болон Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 105 жилийн ой, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчид болон ерөнхий боловсролын ахлан ангийн сурагчдын дунд спортын арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Спортын арга хэмжээг удирдамжийн дагуу өндөр төвшинд зохион байгуулж явуулахыг Цэргийн штаб (хурандаа Г.Нэмэхбаяр)-т даалгасугай.

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах 5,944,000 (Таван сая есөн зуун дөчин дөрвөн мянга) төгрөгийг Цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн орлогын орон нутагт үлдэх хэсгээс зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Наранбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Э.ЭНХБАТ

626010427

D:\2026\1.Zakhiramj\Zakhiramj 01.docx

Аймгийн Засаг даргын 2006 оны 10 дугаар
сарын 13 ны өдрийн 743 дугаар
захирамжийн хавсралт

МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ
105 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ
ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын нэр	Зардлын тооцоо		
		Тоо	Зориулалт	Нийт дүн
1	2	3	4	5
1.	Сурагчдын дунд 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн	12	I байр-1 Эрхийн бичиг II байр-1 Эрхийн бичиг III байр-1 Эрхийн бичиг Медаль Нийт	200.000 40.000 150.000 40.000 100.000 40.000 12x8000=96.000 666.000
2.	Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын эрэгтэй алба хаагчдын дунд "Марш тактикийн аварга тасаг" шалгаруулах тэмцээн	3	I байр-1 Эрхийн бичиг II байр-1 Эрхийн бичиг III байр-1 Эрхийн бичиг Медаль Нийт	500.000 40.000 400.000 40.000 300.000 40.000 42x8000=336.000 1.596.000
3.	"Эх орон - Бидний бахархал" аян зохион байгуулахад шаардагдах зардал	18	I байр-6 II байр-6 III байр-6 Өргөмжлөл-18 Нийт	6x100.000=600.000 6x90.000=540.000 6x80.000=480.000 18x21.000=378.000 1.998.000
4.	Шагайн харваа	27	Өргөмжлөл-7 Медаль-27 Нийт	7x40.000=280.000 27x8000=216.000 496.000
5.	Усан сэлэлт	6	I байр-2 II байр-2 III байр-2 Өргөмжлөл-6 Медаль-6 Нийт	150.000x2=300.000 100.000x2=200.000 50.000x2=100.000 6x30.000=180.000 6x8000=48.000 828.000
6.	Аннос	1	4x6=24мкв	15.000x24=360.000
Нийт		5,944,000 төг		

оОо